



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 15/23

Дуурсах

Г.Батсуурь, Ц.Цэрэнтогтох нарыг ажлаас  
чөлөөлж, сургалтанд хамруулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоол, ЦЕГ-ын даргын 2016 оны б/74 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулах их сургуулийн 2015-2016 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу "Цагдаа-хууль сахиулах ажил" мэргэжлийн эчнээ 5 жилийн хөтөлбөрийн III дугаар дамжаанд цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Ганбатын Батсуурь, цагдаа-жолооч, цагдаагийн ахлагч Цэрэнсодномын Цэрэнтогтох нар суралцах болсон тул 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс 2016 оны 05 дугаар сарын 06-ний өдөр хүртэл хугацаанд үүрэгт ажлаас нь түр чөлөөлөн, тус сургуулийн мэдэлд шилжүүлсүгэй.

2. Дээрх нэр бүхий алба хаагчдын суралцах хугацааны албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг хасаж бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Суралцах хугацаандаа цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахиж ажиллахыг нэр бүхий алба хаагч нарт үүрэг болгож, бичгээр баталгаа гаргуулан авахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2015

515481



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 6/24

Дуурсах

Чөлөө олгож, тэмцээний бэлтгэл  
хийлгэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, “Алба хаагчид чөлөө олгох” /код 934/-ын 934.2.3 /д/-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан Баянхонгор аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдах марш, тактикийн тэмцээнд оролцох нэр бүхий 24 алба хаагчдад 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 15-ны өдөр хүртэл ажлын 10 хоногийн хугацаанд чөлөө олгож, тэмцээний бэлтгэлд гаргасугай.

2. Чөлөө олгож, бэлтгэлд хамруулах алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнд оролцох алба хаагчдын ажлыг зохицуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдуулахгүй байх арга хэмжээ авахыг хариуцсан тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Бэлтгэл сургуулилтыг хийлгэх хуваарь, төлөвлөгөөг гарган батлуулж, түүний дагуу чанар үр дүнтэй бэлтгэлийг явуулж, тэмцээнд амжилттай оролцуулахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Ж.Баярням/ нарт даалгасугай.

5. Тэмцээнд оролцож буй алба хаагчдын цалинг хэвээр бодож олгон, бэлтгэл сургалтын үеийн хоолны зардал, унаа, шатах, тослох материал зэрэгт тухай бүрт нь тооцоог хийж, холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

6. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 6/2н

Дуурсах

Баг хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/77 дугаар тушаалаар хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Буйрцэнгэг, цагдаагийн ахлах дэслэгч Ч.Чинзориг нарыг албан тушаал өөрчлөн томилсонтой холбогдуулан иргэдэд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай хүртээмжтэй хүргэх, багуудад гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулиар харъяалуулсан захиргааны зарим үүргийг гүйцэтгэх, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Баянхонгор сумын 9 багийг хавсралтад зааснаар хэсгийн байцаагч нарт хуваарилан хариуцуулсугай.

2. Хариуцсан багийн объектын судалгааг шинэчлэн гаргаж, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг чанар үр дүнтэй зохион байгуулж, иргэдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, соёлтой хүргэж, “Цагдаагийн ажил, үйлчилгээний стандарт”-ыг мөрдлөг болгон ажиллахыг хэсгийн байцаагч нарт, баг хариуцсан хэсгийн байцаагч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Ж.Баярням/-д тус тус үүрэг болгосугай.


3. “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” /код 102/-ын 102.2.4-ийн “в”-д заасны дагуу хэсгийн байцаагч нарын ажлыг томилгоот эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаанд шалгаж, илтгэх хуудсаар танилцуулж ажиллахыг Ёс журам сахиулах эргүүлүүдэд даалгасугай.

(D)-Alban bichig-Tushaal-2015

515487

3

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын  
даргын 2016 оны 03 дугаар сарын 01-ний  
өдрийн Б/25 дугаар тушаалын хавсралт



**ХЭСГИЙН БАЙЦААГЧ НАРТ БАГ  
ХАРИУЦУУЛАХ ТУХАЙ**

1. Баянхонгор сумын 1 дүгээр багийг хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад Г.Анхбаяр
2. Баянхонгор сумын 3, 6 дугаар багийг хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад М.Цэрэндаш
3. Баянхонгор сумын 4, 5 дугаар баг болон “Дэлгэрэх” захыг хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Бямбажаргал
4. Баянхонгор сумын 2, 7 дугаар багийг хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Мөнхтулга
5. Баянхонгор сумын 8, 9 дүгээр баг болон “Баруун бүс худалдааны төв”, “Есөн-Эрдэнэ” захыг хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч М.Саранцэцэг нарт тус тус хариуцуулсугай.

\_\_\_\_\_000\_\_\_\_\_



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 5/27

Дуурсах

О.Амартүвшинд чөлөө олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Алба хаагчид чөлөө олгох" /код 934/-ын 934.2.3 /а/ дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвчний улмаас чөлөө хүссэн Эрдэнэцогт сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч Очирбатын Амартүвшинд түүний хүсэлтээр 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдөр хүртэл ажлын 7 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Цалинтай чөлөө олгосон цагдаагийн дэслэгч О.Амартүвшингийн цалинг зохих журмын дагуу бодож, олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэгт/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 6/31

Дуурсах

М.Саранцэцэг, А.Алтангэрэл, Ю.Мөнхжин  
нарыг шагнах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн 31.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, "Шагнал, урамшил олгох" /код 925.3.1/, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 135.6.2-ын "г", Цагдаагийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн байгууллагын аварга шалгаруулах "Монгол цагдаа-95" Чингэлтэй дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн нэрэмжит "Шатар"-ын тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Мижгээгийн Саранцэцэгийн албан тушаалын цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувь, "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 95 жилийн ойг тохиолдуулан Баянхонгор аймгийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "Буудлага"-ийн тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Агваанзундуйн Алтангэрэл, саатуулах байрны эмч, цагдаагийн дэслэгч Юнрэнгийн Мөнхжин нарын сарын үндсэн цалинг 1 /нэг/ сар 10 /арав/ хувь тус тус нэмж шагнасугай.

2. Нэр бүхий алба хаагчдын цалинг заасан хувь хэмжээгээр нэмж бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2015

515500





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 5/32

Дуурсах

Галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны мэдээлэлийг оруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.6.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Галт зэвсгийн нэгдсэн санд иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа Монгол улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл авсан, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан, устгагдсан, шилжилт хөдөлгөөн хийгдсэн галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны мэдээллийг оруулах ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Баярням -Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга: А.Алтангэрэл-Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад

Гишүүд:

М.Отгонбаяр-дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Б.Бямбаа- Мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

Э.Баасансүрэн-Захиргааны зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн ахлагч

2. Ажлын хэсгийн удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлыг зохион байгуулж; дүнг 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /цагдаагийн дэд хурандаа Ж.Баярням/-д үүрэг болгосугай.

(D)-Alban bichig-Tushaal-2015

515501

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 8/33

Дуурсах

Сонгуультай холбоотой гэмт хэрэг,  
зөрчлийг шалгаж шийдвэрлэх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, Сонгуулийн тухай Монгол Улсын хуулийн 116 дугаар зүйлийн 116.1, 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Сонгуульд нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах зөвшөөрөл хүсэх” журам /код 309/ “Сонгуулийн санал хураах байр хамгаалах” журам /код 624/, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г” дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын их хурлын болон аймаг, нийслэлийн ээлжит сонгуулийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн ажлын хэсэг байгуулсугай.

2. Сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбаяр-дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга: Н.Өлзийжаргал-Ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч

Гишүүдэд:

Г.Батаа-Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

Ж.Баярням-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Ж.Наранбаатар-эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

М.Гончигсумлаа- Олон нийт хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч

Г.Гансүх- Мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч

Г.Анхбаяр-Хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад

3. Сонгуультай холбоотой гомдол, мэдээлэл зөрчлийг хуулийн хүрээнд шалгаж шийдвэрлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д болон гишүүдэд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 6/37

Дуурсах

Шагнах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн 31.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, “Шагнал, урамшил олгох” /код 925.3.1/, “Байгууллагын даргын тушаал гаргах” /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Цагдаагийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн, “Монгол цэргийн өдөр”, Зэвсэгт хүчний 95 жилийн ойг тохиолдуулан Баянхонгор аймгийн тусгайлсан чигүүрэг бүхий байгууллагуудын дунд зохион байгуулагдсан сагсан бөмбөгийн тэмцээндүүдэд тус тус амжилттай оролцож “Тэргүүн байр” эзэлсэн нэр бүхий 8 алба хаагч, “Ширээний теннис”-ний төрлөөр амжилттай оролцож “Тэргүүн байр” эзэлсэн нэр бүхий 3 алба хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 10 /арав/ хувь тус тус нэмж мөнгөн шагнал олгосугай.

2. Мөнгөн шагнал олгох, алба хаагчдын нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. Нэр бүхий алба хаагчдын цалинг заасан хувь хэмжээгээр нэмж бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2015

515505



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 5/35

Дуурсах

Ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны б/122 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн ахлах хэрэг бүртгэгчийн албан тушаал /ажлын байр/-д Надмидын Өлзийжаргалыг томилсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Батаа-Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга:

Т.Намжилдорж-Дуудлагын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

Гишүүд:

Ж.Наранбаатар-Эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч

Б.Даваацэрэн -Нярав, цагдаагийн ахлагч

2. Ахлах хэрэг бүртгэгчийн албан тушаал /ажлын байр/-д томилогдсон Н.Өлзийжаргалын ажлыг хүлээлцүүлж, дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч Г.Батаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2015

515507



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 6/36

Дуурсах

Ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг  
байгуулах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 6/117 тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн албан тушаал /ажлын байр/-д Хатанбаатарын Гэрэлтуяаг туршилтын хугацаагаар томилсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилэг-Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Гишүүд:

Г.Мөнгөнсүх-Холбоо, мэдээллийн инженер, цагдаагийн ахмад

М.Баянзул-Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч

Б.Даваацэрэн-Нярав, цагдаагийн ахлагч

2. Сэтгэл зүйчийн албан тушаал /ажлын байр/-д туршилтын хугацаагаар томилогдсон Х.Гэрэлтуяагийн ажлыг хүлээлцүүлж, дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2015

515579



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 21 өдөр

Дугаар В/37

Дуурсах

Х.Гэрэлтуяад дадлагажуулагч  
багш томилох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.3, 16.5.5, "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх" журам /код 942/-ын 942.6.4, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн сэтгэл зүйчийн албан тушаал /ажлын байр/-д туршилтын хугацаагаар томилогдсон Хатанбаатарын Гэрэлтуяагийн дадлагажуулагч багшаар Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-ыг томилсугай.

2. Шинээр томилогдсон алба хаагчийг ажил албанд нь богино хугацаанд сургаж, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн алдаа дутагдал гаргах, гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн чиг баримжаатай болгох чиглэлээр удирдамж, төлөвлөгөө боловсруулан 3 сарын хугацаанд сурган дадлагажуулж, явц үр дүнгийн талаар илтгэх хуудсаар танилцуулахыг дадлагажуулагч багш /Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

3. Шинээр томилогдсон алба хаагчид холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулж, 3 жилийн хугацаанд тогтвортой ажиллах гэрээ байгуулж, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн ахлах дэслэгч М.Баянзул/-д үүрэг болгосугай.



4.Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Б.ОЮУТБОЛД